

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Мэдээлэл технологийн алба ОНӨААТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/08-НА-СТА-ОНА

Цахим хуудас:
Дархан-Уул аймаг
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр
Утас: 7037-3089
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 7037-3089
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn
Аудитор: Л.Дамдинжав
Утас: 70376994
Цахим хаяг: dalaivandarkhan@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

45059 Дархан-Уул аймаг
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darhanuul@audit.gov.mn

2021.05.15 № 44

Тайлбар -ны № -т

"МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН
АЛБА" ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Х.СОЁЛ-ЭРДЭНЭ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Мэдээлэл технологийн алба" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Мэдээлэл технологийн алба" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

009020311

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.МӨНХБАЯР

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мэдээлэл технологийн алба ОНӨААТҮГ нь “төрийн байгууллагуудын мэдээ мэдээллийг үнэн бодитоор нэвтрүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах, хүргэж мэдээлэхэд оршино. Мөн мэдээлэл технологийн бодлогыг аймгийн хэмжээнд нэвтрүүлэх, аймгийн ЗДТГ-ын сүлжээ, техник тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хариуцан ажиллаж байна” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Гурав . Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Дархан Бизнес Инкубатор ОНӨААТҮГ нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс бүх мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 12,179.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч аудитын явцад алдааг залруулаа.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ	1	1			1			

НИЙТ											
------	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	4	12.2	4	12.2						
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	4	12.2	4	12.2						